



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2018 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 93

Номгон

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд “Тогтвортой хөгжил-Түншлэл” зөвлөл байгуулж, ажиллах журмыг батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1.е, 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.7, 24 дүгээр зүйлийн 24.1, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 8/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Орон нутгийн цогц хөгжил” төслийн хүрээнд орон нутгийн хөгжилд Төр, иргэний нийгмийн байгууллага, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, уул уурхайн байгууллагын түншлэлийн тэгш оролцоог хангасан “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилго бүхий “Тогтвортой хөгжил-Түншлэл” зөвлөлийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд байгуулж ажиллуулсугай.

2. “Тогтвортой хөгжил-Түншлэл” зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Салбар зөвлөлийг сумдад байгуулж үйл ажиллагаанд үр дүн гаргаж ажиллахыг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарт зөвлөсүгэй.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын 19-ний  
өдрийн 93 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



**“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ТҮНШЛЭЛ”  
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: Ц.Отгонбаяр-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга  
Нарийн бичгийн дарга: Л.Мандаахүү-Баянхонгор Иргэний нийгмийн  
байгууллагуудын сүлжээний нарийн бичгийн дарга  
Гишүүд: Н.Оюун-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч  
/Төрийн төлөөлөл/  
Ж.Хүрэлбаатар-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч  
/Төрийн байгууллагын төлөөлөл/  
Ц.Дашцэрэн-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Төрийн байгууллагын  
төлөөлөл/  
Ж.Баттөр-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Төрийн байгууллагын  
төлөөлөл/  
Д.Дэлгэрсайхан-Хэвлэл мэдээллийн албаны ажилтан /Хэвлэл мэдээллийн  
байгууллагын төлөөлөл/  
Г.Батнасан-Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн нэгдсэн холбооны тэргүүн  
/Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл/  
Д.Ирина-Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн //Иргэний нийгмийн  
байгууллагын төлөөлөл/  
Н.Мэндбаяр-Эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүн /Иргэний нийгмийн байгууллагын  
төлөөлөл/  
Л.Цэдэвсүрэн-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбооны  
тэргүүн /Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл/  
н.Батаа-Корунд гео ХХК-ний гүйцэтгэх захирал /Бизнесийн байгууллагын төлөөлөл/  
Б.Наранбаяр-Худалдаа аж үйлдвэрийн танхимийн Баянхонгор аймаг дахь  
салбарын менежер /Бизнесийн байгууллагын төлөөлөл/  
Л.Одонтунгалаг-“Номгон хүнс” ХХК-ний гүйцэтгэх захирал /Бизнесийн байгууллагын  
төлөөлөл/  
З.Шарав-“Баянжаргант хүнс” ХХК-ний гүйцэтгэх захирал /Бизнесийн байгууллагын  
төлөөлөл/  
Ц.Төмөрбаатар-Эрдэнэцогт сумын Засаг дарга /Сумын төлөөлөл/



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын 19-ний  
өдрийн 93 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



## “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ТҮНШЛЭЛ” ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. “Тогтвортой хөгжил-Түншлэл” аймгийн хамтын ажиллагааны зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1.е, 18.1.2.е, 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.7, 24 дүгээр зүйлийн 24.1, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн тогтоолд зааснаар аймгийн “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн Ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028”-ийг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулах, энэ ажлын явц, үр дүнд хяналт тавихад энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Зөвлөлийн үйл ажиллагааг Зөвлөлийн дарга удирдан зохион байгуулна.

1.3 Зөвлөл нь орон нутгийн хөгжлийн төр, иргэний нийгмийн байгууллага, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, томоохон аж ахуйн нэгжийн түншлэлийн тэгш оролцоог хангасан байна.

1.4 Зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл ажлын хэсгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, эрдэмтэн, иргэдийн төлөөлөгчдийг оролцуулан байгуулан ажиллуулж болно.

1.5 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хуралдаан бөгөөд хуралдаанаар Зөвлөлийн үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үндсэн асуудал, аймгийн “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, Зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө, тайланг хэлэлцэнэ. Зөвлөлийн гишүүдийн олонх нь хуралдаанд оролцож байгаа бол үүнийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

1.6 Зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэл гаргах бөгөөд түүнд Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна. Зөвлөл хуралдаанаараа хэлэлцэх асуудлаар зөвлөмж гаргаж болно. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, зөвлөмжийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан хэрэгжүүлэх

талаар арга хэмжээ авч, түүний явц, үр дүнгийн тухай тогтоосон хугацаанд нь хариу мэдэгдэх үүрэгтэй.

1.7 Зөвлөлийн ажлын албаны үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэнэ.

1.8 Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Засаг даргын Тамгын газрын жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ. “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн Ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” бодлогыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулагдах төсвөөс 5 хүртэл хувийг сургалт, сурталчилгаа явуулах, тэргүүний байгууллага, иргэдийг урамшуулах зэрэгт зориулан Зөвлөл өөрийн мэдэлд жил бүр төвлөрүүлэн зарцуулна.

1.9 Зөвлөл нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тамгыг хэрэглэнэ.

1.10 Зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүн нь зөвлөлийн даргын гарын үсэг, тамга бүхий үнэмлэхтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн зохих урамшуулалтай байх бөгөөд энэ тухай журмыг Зөвлөл өөрөө тогтооно.

## ХОЁР. ҮНДСЭН ЗОРИЛГО

2.1 Зөвлөлийн эрхэм зорилго нь Баянхонгор нутгийнхаа хөгжил, дэвшлийн төлөө нийгмийн бүлгүүдийн бүтээлч оролцоонд тулгуурлан тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад түншлэн ажиллаж, иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулна

2.2 Алсын хараа: Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гаргалт, хэрэгжүүлэлтэнд салбарын хүмүүсийн бүтээлч санал санаачлагыг хүргэсэн, иргэдийн эрх ашгийг хамгаалж чаддаг сум бүрт салбартай зөвлөл байна.

2.3 Зөвлөлийн үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод, хамтын ажиллагаа, харилцан хяналтын тогтолцоонд тулгуурлана.

## ГУРАВ. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1 Зөвлөл нь дараах бүтэцтэй байна.

3.1.1 Аймгий Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 3 гишүүн, аймгийн захиргаанаас (хэлтэс, агентлаг) 2-3 гишүүн, иргэний нийгмийн байгууллагаас 3-4 гишүүн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдээс 3 гишүүн, орон нутагт томоохон хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжээс 2-3 гишүүн

3.1.2 Зөвлөлийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга даргална.



3.1.3 Зөвлөл сард нэг удаа хуралдана. Зөвлөлийн ээлжит бус хуралдаан нь гишүүдийн олонхийн саналаар, даргын санаачилгаар хугацаа харгалзахгүй хуралдаж болно. Зөвлөлийн хуралдааны шийдвэр нь тогтоол байна.

3.1.4 Хуралдаан нь гишүүдийн олонхи хуралдсанаар хүчин төгөлдөр болно.

3.1.5 Зөвлөлийн шийдвэрийг ажлын 3 хоногт аймгийн цахим хуудсанд байршуулж нийтэд мэдээлнэ.

#### ДӨРӨВ. ЗӨВЛӨЛИЙН ҮҮРЭГ, ЭРХ

4.1 Зөвлөл нь дор дурдсан үүрэгтэй.

4.1.1 Нутгийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдийн “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” хөтөлбөрийн хэрэгжүүлэхтэй холбоотой ажлыг аймгийн хүрээнд уялдуулах зохицуулах.

4.1.2 “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” хөтөлбөрийн хэрэгжилтэд эрх хэмжээний хүрээнд хяналт тавих, бүх нийтийн хүч, анхаарлыг чиглүүлэх.

4.1.3 “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” бодлогын баримт бичгийн зорилтуудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг хангах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.

4.1.4 “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар иргэн, байгууллага, аж ахуйн нэгжээс гаргасан санал санаачлагыг дэмжин, тэдний оролцоог ханган, хүсэлтийг судлаж, асуудал боловсруулан хэрэгжүүлэх ажилд хяналт тавих.

4.1.5 “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” аймгийн бодлогыг олон нийтэд сурталчлах, иргэдийн аж ахуй хөтлөх мэдлэг, соёлыг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авах.

4.1.6 Сумын түвшинд “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдний ажлыг шалган зааварлаж, чиглэл заалт өгөх.

4.1.7 Зөвлөлөөс зохиож буй ажлын явц, үр дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

4.2 Зөвлөл нь дараах эрхтэй.

4.2.1 Сум болон аж ахуйн нэгж, байгууллагад “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” хөтөлбөрийн хүрээнд зохиосон ажлын тайланг хагас жил тутамд гаргуулан авах.

4.2.2 Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар нутгийн захиргаа, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах ажилтны илтгэл сонголыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж чиглэл өгөх.

4.2.3 “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийн явц, зарцуулсан хөрөнгийн тайланг аймгийн Засаг даргын Тамгын газраас хагас, бүтэн жилээр гаргуулан авч, дүгнэлт хийх.

4.2.4 Зөвлөлийн эрх хэмжээний хүрээнд хурал, зөвлөгөөн, семинар зохион байгуулах.

4.2.5 “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж урамшуулах, төрийн шагналд тодорхойлох.

4.2.6 Зөвлөлийн шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлээгүй хугацаа хожимдуулсан албан тушаалтанд зохих хуульд заасан арга хэмжээ авахуулах тухай удирдах байгууллагад нь албан ёсоор мэдэгдэх.

#### ТАВ. СУМЫН САЛБАР ЗӨВЛӨЛ

5.1 “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлыг сумд тухайн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргаар ахлуулсан орон нутгийн салбар зөвлөл (цаашид Орон нутгийн салбар зөвлөл гэх) зохицуулна.

5.2 Салбар зөвлөл нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал батална.

5.3 Орон нутгийн салбар зөвлөл нь энэхүү журмыг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн онцлогийг тусгасан журмыг иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар

батлуулан мөрдөж, “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахтай холбогдсон дээд шатны зөвлөлийн шийдвэрийг биелүүлж ажиллана.

5.4 Орон нутгийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэрэг, техникийн бусад үйлчилгээг тухайн Засаг даргын Тамгын газар хариуцах бөгөөд зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_